

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Алтаниширээ сум Зараа багт хамгаалалтын төмөр сараалжин хашаа угсралт ажил.

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ыг тодорхой гаргаж ирүүлнэ. Мэн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, боловсруулж ирүүлнэ.

Б. Хашааны угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

В. Тендерийн үнийн саналд зураг төслийн ажлын зардал 2280700 Долоон зуун эрэн дөрвөн мянга есөн зуун/төгрөгийг, мөн зохиогчийн хяналтын задрлыг техник хяналтын зардлын 50 хувиар тооцож үнийн саналд тус тус тусгаж цруулэх.

Ерөнхий хэсэг: Зараа багт 50,0*80,0 м-тэй 4 тал төмөр сараалжин хашааг дараах техникийн тодорхойлолт болон ажлын зураг, тоо хэмжээний дагуу барьж байгуулана.

1. Суурийн ажил

Бетон суурийн өндөр 0,80 м, өргөн нь 0,30 м байх ба газрын хувьсах түвшингээс 0,4-0,5м дээш гарсан байна. Бетон суурийг хэв хашмалд цутгаж бэлтгэх авсны дараа хэвийг салгаж бүрэн бат бэхээ авталь БНБД-ийн дагуу арчилалт хамгаалалтыг хийнэ. Суурь цутгахдаа хашааны төмөр шонг суулгаж цутгана. Авто ба явган хаалганы хэсэгт суурийг хаалганы өргөнөөр таслаж цутгана. Төмөр сараалжин хашаа, төмөр торон хаалганы ажил бүрэн дууссаны дараа бетон суурийг байгалийн шохойгоор 2 үе чанартай будна. Суурийн нүхний ухаасаас гарсан илүүлэл широог засварлан тэгшилнэ.

2. Төмөр сараалжин хашааны угсралтын ажил

Хашаа нь сууриас дээш 1,0 м өндөртэй хөндлөн огтлол нь 60*60 мм-н төмөр шонд хөндлөн огтлол нь 20*20мм-н хөндий төмөр сараалжин хашааг 2,50 м алхамтайгаар угсарна. Хашааны төмөр хийцийг цахилгаан гагнуураар гагнаж угсралтыг гүйцэтгэнэ. Гагнуурчин нь мэргэжилийн зэрэгтэй байх шаардлагатай. Хашааны төмөр хийцийг төмрийн будгаар 2 үе чанартай будна. Будгийн ажил хийхийн өмнө гагнуурын сэвийг цэвэрлэж гагнаасын чанарыг шалгасан байх.

3. Төмөр торон хаалганы угсралтын ажил

Авто хаалга нь 1,48 м өргөн, 1,30 м өндөртэй 2 самбартай, явган хаалга нь 0,79 м өргөн 1,30м өндөртэй байна. Хийц нь 50*50*4 мм-н адил талт булан төмөр хүрээтэй цайрдсан төмөр торон самбартай байна. Хаалганы хүрээг төмрийн будгаар 2 үе чанартай будна.

Төндөрт шалгарсан гүйцэтгэгч нь: импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал "Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ" лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

Хашаа байгуулах ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн дагуу чанарын баталгаа гаргаж өгнө.

Хэрвээ зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлгөч, зураг төслийн зохиогч эрхийнхээ дагуу тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

Үнийн саналыг Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Төсөвт цалингийн зардлыг БХБ-ын сайдын 2019 оны 217 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.